

## ДУНДАТ ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛЫН ДОТООД ЗӨРЧИЛ ТЭМЦЛИЙН УГ СУРВАЛЖ, СУРГАМЖ

Ч.Сосорбарам

Батлан Хамгаалах Яам, [sosorb58@yahoo.com](mailto:sosorb58@yahoo.com)

**Өгүүллийн товч утга:** Монголын түүхийг зориуд бодлогоор гүйвуулах судалгаанууд их байдаг. Эдгээрээс болон өөр олон хүчин зүйлээс болоод улс орныхоо түүхэн дотоод зөрчил тэмцлийг ч манай түүхид бүрэн хэмжээгээр тайлбарлаж чадаагүй явж иржээ. Иймд монголчуудын дотоод зөрчлийн түүх, үр дүнг тодруулах цаашид анхаарах асуудлын талаар монголчууд тусгаар тогтолоо алдахад хүргэсэн "баруун, зүүн"-ий тэмцлийн уг үндэсийг эргэн нягтласан юм.

**Түлхүүр үг:** олон ястан, угсаатан, улс үндэстэний аюулгүй байдал

Саяхан Манжийн Энх амгалан хааны талаархи хятадын телевизийн олон ангит киног манай үзэгчид шимтэн үзсэн билээ. Тэд нэг талаас киноны зохиомжийн сайныг нөгөө талаас хятадын төрийн бодлогын нарийн ухааныг Галдан Бошигтыг яаж дээдлэн халхын ноёдыг хэрхэн доош нь хийж байгаагаас харж нэгийг бодсон биз ээ. Энэ нь зүүн баруун хэмээн зөрчилдүүлэн эртний хүннүчүүдийг бутрааж тараасан<sup>1</sup> сонгодог уламжлалт аргаа саяхан XVII дугаар зуунд амжилттай давтсан төрийн бодлогоо хятадын түүхид гайхуулж байгаа хэрэг биз.

Иймэрхүү маягаар монголын түүхийг зориуд бодлогоор гүйвуулах судалгаанууд их байдаг. Даяаршил, мэдээллийн хөгжлийн энэ зуунд үеээ өнгөрөөсөн үзэн ядалт, гомдол, их үндэстэний нарийн бодлого монголын түүхийг тойрон үргэлжилсээр байна. Их оросын, хятадын династик, христианизм, еврейн түүхийг үзэх үзэл, соёл иргэншлийн талаас түүхийг тайлбарлагчид, марксист ленинист онолчид, лалын ертөнц, барууны уламжлалт зэрэг өнөөдөр ноөрхож буй түүхчидийн ихэнхи биднийг бараан талаас бичсээр ирсэн. Ер нь өөртэй нь өрсөлдөж байсан нүүдэлчидийг магтан дуулахгүй нь ойлгомжтой.

Эдгээрээс болон өөр олон хүчин зүйлээс болоод улс орныхоо түүхэн дотоод зөрчил тэмцлийг ч манай түүхид бүрэн хэмжээгээр тайлбарлаж чадаагүй явж иржээ. Жишээ нь нэг бол Галдан Бошигт эх оронч, Өндөр гэгээн урвагч, эсхүл Галдан тусгаар тогтолоо алдахад хүргэсэн буруутан, Өндөр гэгээн бурхан гэцгээх туйлшрал үргэлжилсээр...

Ингээд монголчуудын дотоод зөрчлийн түүх, үр дүнг тодруулах зорилгоор дундат зууны хэдэн зууны турш үргэлжилж эцэст нь тусгаар тогтолоо алдахад хүргэсэн "баруун, зүүн"-ий тэмцлийн уг үндэсийг дахин нягтлахдхь орчин цаг үед юу нь сургамж болохыг хамтатган авч үзье.

### Өгөдэй ба Толуйн удам

Төр улсаа төвшигтэн товхинуулж дуусаад морин дээрээс буусны дараа буюу дэлхийд тэргүүлж байсан Өгэдэй, Гүег, Мөнх хааны үед Монгол Улс нэгдмэл байлаа.

Гэтэл Хувилай өөрийгөө хаанд өргөмжилж төрсөн ах Аригбухтай (1260-1264) сөргөлдөн байлдах болсноор улс гүрний дотоод зөрчил тэмцлийн эхийг тавьжээ. Аригбөхийн дараа Өгэдэйн ач хүү Хайду (Хашийн Хайду<sup>2</sup> 1235-1301), -

<sup>1</sup> Л.Н.Гумилев Хүн гүрэн. УБ., 2000

<sup>2</sup> Мөнхийн эсрэг хүйвалдсан хэмээн Тарвагатайд цөлөгдсөн. Дэлай Монголын түүх. III боть, УБ., х-45

гийн талынхан \тулгуур аймаг нь ойрадууд\ Ил тарвагатай орчимоос эхний үед Цагадайнхны дэмжлэгтэйгээр Хувилайн эсрэг тэмцэлийг үргэлжлүүлж байв.

Энэ нь ч түүхэн учир шалтгаантай бөгөөд Чингис хаан залгамжлагчаа тодруулах явцад Зүчи, Цагадай нар зөрчилдэж эцэст нь Өгөдэйг нэр заах үед тэрбээр "үр удамд нь олигтой хаан ширээг залгамжлах хүн гарагчийг эсэх тухайд санаа зовж байсан" түүхэн баримт байдаг бөгөөд Чингис хаан танай удмаас биш юм гэхэд ах дүү нараас эрхбиш залгамжлагч олдоно биз гэж хариу айлдсан гэдэг.<sup>12</sup> Харин хаан ширээнд залагдах үедээ Өгөөдэй бусад ах дүү нараасаа өөрийн удам тааруухан байсан ч гэсэн хаан ширээг залгамжлуулах ам авч байжээ. Өгөөдэй хаан нас барсны дараа хатан Турхан 4 жил төрийн эрх барьж байгаад бусад алтан ургийнхний шахалтаар Гүюг Их хаан болсон билээ. Энэ үед Өгөөдэйн удмыг ялангуяа Гүөгийг Цагаадайнхан, Толуйн удмынхныг Зүчийн хүү Бат дэмжиж байсан гэдэг.

Баруун Монгол буюу өнөөгийн буриад, Тувагийн нутагт байсан ойрадын олон аймгуудыг 1207 онд Зүчи нээгтгэж дөрвөн мянгат болгож байв. Монголын язгуурын гол овог хиадаас гаралтай эхний овгууд бол боржигин, дүрвэд юм. Дүрвэд аймаг ойрадуудад хамарагддаг.

Тэд 1217 онд хорь түмэдийн бослого дарагдсаны дараанаас баруун тийшилж Алтайн ар өврөөр нутаглах болсон бөгөөд Чингис хаан Өгөөдэйд 4 мянган хуяг өгч Ил Тарвагатайг\Хами\ эзэмшүүлснээр түүний мэдэлд уйгурууд төдийгүй түүний бэр Ойрадын Хутугу бэхийн охин Огул каймишыг \1248-1251\ даган ойрадын аймгууд оржээ. Огул каймиш \1248-1251\ Гүюг хааны их хатан журамтай сайн эхнэр байв.


Толуй Онон, Хэрлэн, Орхон, Туул, Сэлэнгэ тэргүүтэй Монголын гол орныг эзэмших эрхтэй буюу монголын язгууртны гол овог хиад боржинуудыг захирч байсан байдал, Турхан хатны болчимгүй улс төрийн ажиллагаа, түүнд эгдүүцсэн нөлөөт Бат хааны дэмжлэг зэрэг нь Их хуралдайгаас Гүюгийн дараа Толуйн удмын Мөнхийг хаан ширээнд залахад хүргэжээ. Мөнх хаан өөрийгөө эсэргүүцэгчид болох Турхан, Фатима нарыг Ширэмүн хан хүүгийн хамт цаазалсан нь их гүрний ирээдүйн дотоод зөрчлийн нэг эх үүсвэрийг тавжээ. Мөн үүнд Турхан исламын талыг барьдаг байсан бол Мөнх, Ариг бөх, Хулагу, Хувилай нарын хаадыг төрүүлж өсөгсөн хэрэйдүн хаан агсан Тоорилын дүү Жаха хамбын охин ухаалаг Сорхогтуна хатаны\Толуйн их хатан\ ариун үнэн алдартны шашныг дагадаг байсан нь ч нөлөөлсөн байж болзошгүй.

**Ингэж Хувилай хууль бусаар хаан болсон ганц хэрэг явдал Их гүрнийг гадаадын ямар нэг нөлөөлөлгүйгээр дотроосоо бутаргахад хүргэж Их хаадын залгамжлагчид тус тусын мериийг хөөжээ.Зураг №2**  
Монгол Гүрэн Алтан орд-Хөх-цагаан орд, Ил хаад, Цагаадай –Могул, Юань – Давааны ар улс гэх мэтээр бутарч, Зүчи, Цагаадай, Хулагу хаадын удам Ногай, Узбек, Татар, Доголон Төмөр, Бабур зэрэг хаадаар үргэлжилэх болсноор Ногай, Узбек, Татар, Цэцэн–Чечень нарын нэртэй ард түмэн улсууд ч үүсэв. Гадаад хамгаалалт бутран унаж Их хаадыг залгамжлагчид хоорондоо байлдаж байжээ. Үүнд Бэрх, Хулагуний дайн, Доголон Төмөрийн Алтан ордны эсрэг аян дайн гэх мэт...

### Их Хаадын түүх


Есүхэй/хиад ясны, боржигин овгийн\

### Зураг 2



<sup>1</sup> Монголын нууц тохиргоо

<sup>2</sup> Далай Монголын түүх. III боть, УБ., х- 40



Ар, эвэр зуун, баруун түмэд, хорчин ба ойрадууд

2. Бээжинд 100 гаруй жил сууршсан Хувилай хааны удмын хаад (1260 – 1368) төргөн цэргийн хамт Бээжингээс хөөгдөж гарсан билээ.. Юань гүрний дараа буюу 40 түмэн монгол 4 түмэн ойрадаас бүрдсэн монгол гүрэнд хятадаас хөөгдсөн Толуйн удмын хаадын нэр хүнд, хүч нөлөө багасахын сацуу Өгөөдэйн ач хүү Хайдугийн хойчисын нөлөөнд байсан ойрадын Тэгён, Эсэн болсон Хасарын удмын хорчин, горлос удмын ноёд, тайшууд Адай, Аругтай нар сэргэжээ.

Ингэж монголчууд ар, өвөр болон ойрадууд, хорчин, оннигуд нар хэмээн Толуй, Өгөөдэй, Хасар, Бэлгүтэйн удмынхнаар ноёрхсон аймаг, түмэдээр хуваагдаж дотоод шинэ зөрчил тэмцэл нь эхэлсэн билээ. Юань гүрний үед хятад сурвалжуудад бодлогоор дорнод монгол, ойрад, энгуд, урианхайчууд гэж монголчуудыг хубаан нэрлэх болсоны үр дүн ингэж гарч эхэллээ.

Баруун монгол буюу ойрад аймгууд бага хаадын үед дараах шалтгаанаар төвтэйгээ тэмцэлдэх болжээ. Үүнд:

Тэд түүхэн тодорхой цаг үеүүдэд ялангуяа бүрэлдэн төлөвшиж байх үедээ Зучи, Хайду нарын төвтэйгээ зөрчилтэй хаад, ноёдын удирдлаган доор

явж ирсэн учраас төв засгийн зарим урагшгүй үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах сэтгэлгээ хэвшсэн,

Ойрадууд Сибир, Хөвсгөлийн ойгоос баруун урагшаа гарч ирээд зам харилцааны зангилаагаа, их бага хаадын холбоосон дээрх өргөн уужим орон зайд нутаглаж Юан гүрний эхэн үед ойрадад их хааны дөрвэн сүрэг байсныг дөрвөн ноёд захирч байсаар дөрвөн ойрад гэх болсон<sup>1</sup>, мал, сүрэг хүн ам огцом өсөн хүч чадал нь өсөхийн сацуу дундат азийн Цагаадай, Зүйийн гүрний зах хязгаар киргиз, кипчакийн жүүз, аймгуудыг довтолж баяжиж эдийн засгийн хувьд бэхжсэн.

Тайш, ноёд нь угсаа гарлын хувьд чингисын удмын ноёд, хатадын үр удам боловч адил эрх эдэлдэггүй, Жишээ нь: Гүюг хаан, Хайдугийн удам ойрадад үргэлжилж, Тогоон тайшийн хүү Эсэн тайш "хаан" өөрөө Элбэг нигүүлсэгч хааны зээ хүү байсан бол Батмөнх Даян хаан нь Баянмөнх жонон халхын Харгуцаг тайж, Эсэн тайжийн охин Цэцэг нарын хүү байсан зэрэгээр тэд хаадтай ах дүү хамаатан садангууд байлаа. Ойрадын үе үеийн олон отог аймгуудад тогтсон язгуурын ноёд байгаагүй бөгөөд хэн төвийн түмнийхэнтэй (Чингис, Өгөөдэй, Хасар, Элбэг, Батмөнх, Алтан, Автай гэх мэт) худ, ураг болсон нь илүү эрх мэдэлтэй болж бусдыг дагуулж байсан бөгөөд ойрадын түүхэнд удаан хугацаагаар хэний ч ураг удам дангаар тэргүүлж байгаагүй юм. (Хүснэгт №1-т) Ойрадын Цорос, Өөлд, Дөрвөд, Хойд, Торгууд, Хошууд аймаг отгуудаас Элбэг Хаан үед Төрийн сайд нь Хуха Таюу байж Цоросын Бахаму, Торгуудын Тайван, Ойрадын Батула нар голлох ноёд байсан бол Эсэн тайш алагдсаны дараа ойрадыг Баатудын Алагтөмөр, Асудын Хатан төмөр, дүрвэдийн Өштөмөр тайш, Борогал зэрэг өөр өөр аймгийн ноёд тэргүүлж байснаас тодорхой харагдана.

Нүүдэлчидийн төв засгийн газраас (Толуйн удмынхаас) харьяат аймгийн язгууртнуудыг эдийн засгийн хувьд урамшуулах чадалгүй болсон "хятадаас авдаг татвар үгүй болсон зэрэг..." нь зах хязгаарын ноёдыг төвөөс зугатаалгах гол шалтгаан болж байсан.

Өвөр монголчуудын хувьд ч аймаг түмэдийн үүрэг зориулалт, газар зүйн байрлал, угсаа залгасан ноёдын хувьд ч "Хасарын удам" гэх зэрэгээр төвтэйгээ зөрчилдэх дээрхтэй төсөөтэй болон өвөрмөц нилээд олон шалтгаан байсан.

Мөн зөрчил тэмцэл нь нэг талаас шинэ хуучны буюу удам залгасан хаадын хуучны язгууртнуудын сул байдал нөгөө талаа шинээр хүч түрэн орж ирсэн шинэ язгууртнуудын идэвхийг харуулж байгаа бөгөөд эцсийн дүндээ феодлын харилцаа хямралд орж улс гүрэн бутрах үйл ажиллагаа гаднын нөлөөгөөр улам бүр ихсэх болов.

Чухам энэ үе хамгийн ээдрээтэй цаг байжээ. Учир нь бага хаадын үеийн бутрал нь Хаан жонон хоёрын зөрчил, нөгөө талаар ойрэдын тайш, хорчин нарын (Өгөөдэй, Хасарын удмынханаас) Хубилайн угсааны хаадын эсрэг хийсэн тэмцэлээс үүдэлтэй.

Үүний нэг тодорхой жишээ нь "Боржигини Хувилайн үрийг таслах" гэж ойрадын ноёд цугларч... "Агваржин жононд хаан цол өгөхөөр өөрийн цолоо Эсэн тайшт соёрх" гэсэн хурим бэлдэн жононг залав. Гэрийн дотор гүн их нүх ухаж, нүхэн дээгүүр эсгий дэлгэж жонон эхлэн 33 өрөвлөгтэн, 44 отготон, 61 хэгэрийтэнийг нэгэн үүдээр оруулж хороов."<sup>2</sup> Ингэснээр Хубилайн удмыг бүр мөсөн мөхөөж монголын хаан ширээнд "хэнийг" ч тавьж болох үүдийг тавих гэсэн оролдлого гарчээ.

<sup>1</sup> Далай Монголын түүх. III боть, УБ., х- 53

<sup>2</sup> Лувсанланzan. Алтантоевч.УБ., 1990

Ойрадын тайшууд хаан, жонон хоёртын зөрчил дээр тоглож байр сууриа олох арга хайж, түүнийг нь Мин улс дэмжиж хаан, жонон ноёд нарт өөр өөр бэлэг өгөх зэргээр тэдгээрийн зөрчлийг дэвэргэхдээ гаргууд байжээ.

Дараахь хүснэгтээс Монгол үндсэндээ гурван хэсэгт хуваагдаж бага хаад голдуу тэдгээрийн зарим хэсгийг л хянаж байсныг харж болно. Зарим үед ойрад ноёд төрийн хэрэгт нөлөөтэй оролцож байсан бол төвийн хэсэг нь урдуур нутаглаж байсан бага хаадаас харьцангуй бие даасан байдалтай байжээ.

**Үүнийг "Багахаадын засаглалын хуваагдал" Хүснэгт №1-д харуулаэв.**

ОН	Төв хэсэг буюу <b>Халх</b>	Өвөрモンгол: Цахар, Түмэд,	Ойрад Цорос Дөрвөд Хойд Торгууд Хошууд
1370-78	<b>Аюушридар Билэгт хаан</b>		
1378-88		Төгстөмөр хаан <b>түүнийг</b> Мин Улс Майдарбалыг хаанаар тавих гэж Хайдугийн удмын Есөнтөмөрөөр алуулав	
1388-92	<b>Энхзоригт хаан ТөгсТөмөрийн хүү</b>		
1392-99		<b>Элбэг Хaan ТөгсТөмөрийн хүү Төрийн сайд-ТС Хуха Таюуг хороож Ойрадыг тулхэж зөрчлийн эхийг тавив,</b>	
1399	Дүүрэнтөмөр хун тайж ТөгсТөмөрийн 3-р хүү	Гүнтөмөр Хааныг <b>Элбэг Хааны хүү</b>	Цоросын Бахаму, Торгуудын Тайван,
1402		<b>Хойдын Гуличи ноён Мин тэй хуйвалдан алав</b>	Ойрадын Батула
1402-1408		<b>Уяч Хашха хаан—Хойдын Гуличи ноёныг Арутгай алав.</b>	
1408-1411	Халхын Ажаа тайж	<b>Буяншир Хаан-</b> биеэ өрг\ <b>Элбэг Хааны хүү</b> <b>ТС Арутгайтайгаа</b> байлдаж ялагдав.	Буяншир Хаан Ойрадад зугатаж очоод Бахамуд алагдав
1412-1415	Агваржин Жонон Ажаа тайжийн хүү	<b>ТС Арутгай</b> Мин хамт ойрадыг довтолж Тогооныг боолчилж, баруун монгол тусгаарлах замыг нээв	<b>Дэлбэгийг</b> Хаанаар Ойрадын Бахаму <b>ТС</b> өргөмжлөөд алав
1430-1452		<b>1.Адай\Хасарын удам\ Хаанаар ТС Арутгай</b> өргөмжлөв.	<b>2.Тайсун Тогтобухыг</b> <b>\Ажаа тайжийн хүү\ Хаанаар ТС Тогоон тайш</b> өргөмжлөв.
	Халхын Харгуцаг тайж Агваржин Жононгийн хүү	<b>Тайсун Тогтобух Хаан Ажаа тайжийн хүү, Тогоон тайштай эс эвдэрч байлдан ялагдаад хадам агсан Горлосын Цавдан ноёнд алагдав.</b> <b>ТС Тогоон тайш!</b> Батулагийн хүү\ Адай, Арутгайтай байлдаж алав	

1451-1455	<b>Эсэн тайш\ Тогоон тайш, Элбэг хааны охины хүү\ биеэ Хаанд өргөмжлөөд Баатудын Алагтөмөрт алагдав,</b>		
1455-1461	Баянмөнх жонон. Мандуул дүүгээ ховоор хороов	<b>Маркус\Тайсуны хүү\ Хорчин Болой,</b> Мулихай нар өргөмжлөөд Болой өөрөө алав. Түүнийг Мулихай алав	<b>Баатудын Алагтөмөр Асудын Хатан төмөр</b>
1461-1462		<b>Молон\ Тайсуны хүү\онигиуд Мулихай өргөмжлөөд бас алав.</b> өөрөө Хорчин Өнөболдод алагдав	
1462-1467		<b>Мандуул биеэ өрг\Ажаа тайжийн хүү, Тайсуны дүү\ \Цахар голлох болов\</b>	<b>Өштөмөр тайш</b>
1460-1504	<b>Мандухай хатан ТС Батмөнх Даян Хаан \Халхын Харгуцаг тайж, Эсэн тайшийн охины хүү\ Ибэрэй тайш</b>		

Энэ цаг үед.govийн урдуур нутаглаж байсан бага хаад бараг бүгд бусдад (ойрад, хорчин нарт) алуулах буюу үр удам нь тасарч алга болж байв. Бага хаадын хойд талдаа "халх"-ын гэсэн тодотголтойгоор төвийн түмнээ (хиадуудыг) удирдаж байсан хүүд дараагийн хаадыг төрүүлж байжээ.<sup>1</sup> Жишээ нь: Халхыг захирч байсан Дүүрэн төмөр хунтайж, Ажаа тайж нарын удам болох Тайсун, Мандуул нар тасрах шахсан бага хаадын аргамжааг үргэлжлүүлсэн бөгөөд халхын Хархурцаг тайжийн удам Батмөнх Даян хаан, энэ аргамжааг таслаагүй сэргээнээр түүний удам Гэрсэнз, Онох, түүний хүү Автай сайн хаан, Түшээт ханууд уламжлан монголын нутгийн төв хэсэг гол голомтийг хариуцаж ирсэн түүх гэрчилдэг.

Халх гэгдэх аймгууд Их хаадын язгуур төрийн голлох төв хэсэг-орхон туулын билчир хиадын нутгийг хамгаалах үүрэгтэй байсан бол цахарууд бага хаадыг хамгаалах хишигтэний үүрэг, цаашилбал халх монголын өндөрлөгийг урд талаас хятадаас халхлах төр, цагийн бодлогын хэлхээс байжээ.

Эцэст нь Чингис хааны дүү нарын хойчис оннигуд нар үүрэг, эрхээ хэтрүүлэх болсон ойрадуудтай холбоотон байхаа больж Толуйн удмыг дахин дэмжсэнээр л 1454 онд Тайсун Тогтабух хааны хөвгүүд хаан сууринд сууцгааж ойрадуудыг баруун тийш нь буцаажээ.

### Халх ба зүүн гарынхан

Ё. 1492-1502 оны үед Батмөнх Даян хаан дотоодын олон отог, овгийн зөрчилдөөнөөс болж ихээхэн зүдэрсэн хүний хувьд нэгдүгээрт нутгийн төв хэсэг, гол уугул овог, отгоо халхлан хамгаалах нүүдэлчидын төрийн бодлогыг сэргээнээр төрөө төвхнүүлж чаджээ. Хоёрдугаарт 11 хүүдүүдээрээ монголын бүх зонхилох аймаг хошуудыг удирдуулан боржигин удмаар монголын бүх язгууртнуудын угийн эхэнд тавих бодлогыг эхлүүлжээ. Дараа нь Гэрсэнзийн 7 хүүдүүд дахин зохион байгуулагдсан халхын 7 отог, хошууг захирах болсноос төв отгийг нь Оноход өгчээ. Энэ мэтчилэнгээр 100 гаруй хошууд бий болж 300 гаруй жил оршсон билээ. Батмөнх даян хааны угсааныхан өөрсдийгээ дан боржигин овогтой хэмээх болжээ.


Монголын Ханууд, Төрийн Тэргүүнүүд

Зураг №3г

Батмөнх Даянхаан

<sup>1</sup> Ч.Сосорбарам. Сүүлчийн хиад. МУИС.ЭШБ. №228. УБ., х.39-48

Ханууд:



Ар монгол нутаглаж байсан аймаг түмэдүүд, хошуудад хуваагдан хил хязгаартай болж нүүдлэх нь хязгаарлагдсан болон бүх хошуудад Даян хааны удмынхан хувиарлагдан тархаснаар<sup>1</sup> олон овог, отог угсаатны хувьд ижилсэж ойртжээ. Ингэснээр "халх" хэмээх орчин үеийн монгол үндэстэнийг бүрдүүлэгч гол угсаатан төрөх үндсэн нөхцөл болжээ дүгнэлтэд хүрч байна.

Ингэж "халх" түмэд боржгин угсаатай холилдон монголчуудын гол угсаатны жинхэнэ нэр болон хэлбэржин тогтсон бөгөөд Батмөнх Даян хаан, Гэрсэн, Автай сайн хаан нарын үүрэг их байжээ. Ингэж олон угсаатны "халхлах түмэд" явсаар **халх монгол хэмээх шинэ үндэстэн** бүрэлдэн бий болсон талаарх түүхэн баримтууд Гонгор гуйн ном<sup>2</sup> онд дэлгэрэнгүй байдаг.

Автай сайн хаан шашныг дэлгэрүүлж, ойрадыг нэгтгэн удирдаж байсан учир "Түшээт хан" цолыг Далай ламаас авч байжээ гэх мэтчилэн Даян хаан, Алтан хаан, Автай нар ойрадыг хүчээр захирч байсан ч халх шиг ойрадын бүх хошуу, отогт үр удмаа захиран суулгаж чадаагүй учир монголчуудад боржигин ноёдтой-халх ба боржигин ноёдгүй-ойрат (Өгөөдэй, Хасарын удмынханы ноерхсон) хэмээх "ялгавар" бий болсон, Сүүлчийн Лигдэн Хаан зөвхөн цахарыг захирч Нурухач баатарын тэргүүлсэн Манжийн холбооны Алтан улс (1617)-тай тэмцэхдээ хятадын Мин Улстай холбоотон болсноор Ихээхэн мөнгөний төлөө<sup>1</sup> бусад өвөр монголын аймгуудыг өөрийн эсрэг босгов. Монгол цэргийн сургууль төгсч, монгол ноёны гэрт өссөн хорчин хатантай Нурухач баатар Мин улсаас

<sup>1</sup> Боржигин овог үүгүй хошуу сум ар, өөрийн халхуудад байхгүй байсан бөгөөд урианхай, харнууд шарнууд зэрэг бусад олон овгийн адил өнөөдрийн халхын бүх сумдад тархаж ялгаж салгахад хэцүү болжээ.

<sup>2</sup> Гонгор.Д Халх товчроон. боть I. УБ., 1970. х-137

шинэ улсаа хамгаалах тэмцэлдээ амжилт олсон төдийгүй Мин улсыг довтлох болж, өвөр монголын аймгуудыг холбоотон болгох талаар чармайх болов. 1624 онд хорчин, дөрвөд, жалайр, горлос аймгууд Манжтай холбостон боллоо. Дараа нь аохон, найман, баарин, онигуд, горлос, хишигтэн түүнд элсэв.

Лигдэн хаан 1625, 1631 онуудад тэднийг довтолоход хариуд нь хорчин, түмэд, юншээбүү, ордос, авга нэгдэж цахарыг довтлов. Араа нь Манж, асуд, хорчин, найман хамтарч Лигдэнг довтлож 1632 онд (цахарыг) бутцохив.

Лигдэн хаан гадаад талдаа хятад, манж хоёрын эсрэг улс төр дипломатын олигтой арга ч хэрэглэж чадсангүй, монгол аймгуудаа тэргүүлэн нэгтгэж ч чадсангүй байсаар дийлэгдэв. Энэ нь нөгөө талаас Мин улсыг Манжтай нэгтгэж монголын эсрэг нэгдсэн фронт болгохгүй гэсэн Лигдэн хааны улс төр дипломатын арга ядсан бодлого ч байсан байж болзошгүй.

Өвөр монгол Манжийн холбоотон болсон, монголын Хаан Лигдэн нас барсан, 1634 оны баруун, зүүний эө найрамдлын гэрээ бүтэлгүй болсон, халхын дотоод хануудын сөргөлдөөн зэрэг нь Эрдэнэбаатар хунтайжийг **Зүүн гарын улсыг** байгуулахад хүргэжээ. Товчондоо монгол хаангүй болсон үед төр улсаа авч үлдэх гэсэн сүүлчийн оролдлого байлаа.

Дээр нь буриадаар дамжуулан сибирийг колончлож эхэлсэн орос болон хятад, манж нарын ашиг сонирхол нэгдэж монголчуудыг аль болох сулруулах олон талын идэвхитэй үйл ажиллагааг явуулж байв. Оросууд буриадыг эзлэх гэж Түшээт хантай байлдаж байсан үедээ тэд өөлдийн Галдан Башогтод нууц дэмжлэг үзүүлж 1671-1688 онуудад Занабазар Өндөр гэгээн-Богд түүний дүү Түшээт хан Чихундорж нарын үед Засагт хан Норов нас барж түүний залгамжлагчидын хооронд будлиан гарсныг шалтаг болгон Халхыг довтлуулснаар баруун, зүүн хоёрын хооронд дайныг эхлүүлж чадлаа. Галдангийн аллага хядлага\Хиадуудын нутагт Хөгнөхаанд санваартан Галдан лам нарыг ч хөгнөж байсан\, Оросын түрэмгийллээс үүдэн халхын нсёдод өвөр монголчуудтай холбоотон болсон шашин ижил, ахуй ойролцоо, саяхан дагалдагч байсан Манжийг түшихээс өөр гарц үлдсэнгүй.

#### Нэгдэл, бутралын –түүхэн товчоо

Он	Халх	Өвөрмонтгол: Цахар, хорчин, горлос...	Түмэд,	Ойрад Цорос Өөлд Дөрвөд Хойд Торгууд Хошууд
1460-1504	<b>Мандухай хатан ТС</b> <b>Батмөнх Даян Хаан</b>			
1506-1547	Гэрсэнз 1513-1549,	<b>Ах Барс болд</b> Боди алаг Хааныг орлов <b>Боди алаг Хаан</b>		
1547-1558 үед	Онох III хүү 1534,	Дарайсун Их хаан Хянганы цаана Алтан хаанаас эмээж нутаглаж байв.	Баруун түмний <b>Алтанхаан</b> (Барсболд хааны ач) Түмэд, ойрад, Хөх нуурт, Хөх хотод Далай ламыг урьж шарын шашиныг дэлгэрүүлэв.	
1558-1593	<b>Автайсайн Түшээт хан</b> Шолой Цэцэн хан Субайдай	<b>Түмэн засагт Хаан</b> цахар, Ордос, юншээбүү, өвөр монгол		<b>Алтанхаан</b> түмэд, ойрад, Хөх нуур

1593-1603	Засагтхан		Буянт Хаан	Автайсайн Түшээт ханы хүү Шибагудай Ойрадыг захирав
1603-	<b>Эрээхий Түшээт хан</b> Цэцэн хан Засагтхан  Онохын Бахарайн хүү Цогт тайж 1580-1637 1621-Дуут хад	<b>Лигдэн Хаан</b> (Цахар)  Минтэй холбоот он	1617 Манжийн холбоо Алтан улс, <b>Нурхач баатар</b> хорчин хатантай I-т 1624 хорчин, дөрвөд, жалайр, горлос Манжид дагаар оров. II-т аохон, найман, баарин, онигуд, горлос, хишигтэн элсэв. - Лигдэн 1625,31 тэднийг довтолход хариуд нь хорчин, түмэд, юншээбүү, ордос, авга нэгдэж цахарыг довтлов - Манж асуд, хорчин, найман хамтарч Лигдэнг довтлов. - Манж 1632 онд Лигдэнг (цахарыг) бутцохив.	<b>Хархул ноёны</b> үед -1607 торгууд Хоо өрлөг халимаг руу 50000 өрх, -Ойрадаас Хошууд Убаш тайш 3000 өрх Ижил рүү, Хошуудын <b>Гүүш байх</b> Хөх нуур луу нүүв, Халхын Цогтыг цохив.
1634	Гомбодорж Түшээт хан	1636 ӨМ 16 аймаг,49 ноёд Манжид дагаар оров		Эрдэнэбаатар хунтайж 1634-1663
1634	Гомбодорж + Цэцэн хан,-Засагтхан , Эрдэнэбаатар хунтайж, Хөх нуурын Гүүш байх, Халимаг28 ноёд цааз, Шашин, найрамдал			
	Цэцэнхн 1652, ТүшХ55, Зас.Х 60 : Нас барав	Бутрал <b>Манж</b> <b>Энх амгалан хаан</b>		Эрдэнэбаатар тайш <b>Зүүнгарын хаант</b> улсыг 1635 онд байгуулав.
1639	Занабазар Өндөр гэгээн- <b>Богд</b>			Галдан Бошигт 1671-1688
1650 1661	Чихундорж -ЗасХ Норов нас барж будлиан тарив.			Халхыг довтолж Манжид 1690-т ялагдав. Ховдод 1995, Туул Хэрлэнд 1696 дахин ялагдав.

Манжид нийлэлгүй үлдсэн монголын хоёр хэсэг хоорондоо байлдахаар хэн хожих нь ойлгомжтой билээ.

Энэ хооронд хүчирхэгжин монголыг нэгтгэж магадгүй болсон Галдан бошиглаас эмээсэн Орос, манж улсуудын шууд болон шууд бус оролцоотой Галдангийн ар талд ойрадад төрийн эргэлт гарчээ. Монголчуудын ээ звдэж чадсан манж нар 1690 онд Хэнтийд, 1995 онд Ховдод, 1696 онд дахин ялагдав.

Туул Хэрлэнд Галданг бут цохисноор Монголчууд тусгаар тогтолыг үгүй болгож чадав.

Ингэж монголчууд XVII зуунд тусгаар тогтолоо дотоод зөрчлөөсөө үүдэн өөрснөө өөрийнхөө гараар егүүтгэсэн билээ.

### 3. Орчин үе ба дээрх түүхэн үйл явдлуудын сургамж

Өнөө цаг үед ч ойрад болон өвөрлөгч нарыг монголоос ондоо ангид юм гэх үзлийг монголын түүх судлалд байлгахыг орос, хятадын эүгээс нарийн бодлогоор дэмжсээр байгааг эхэнд дурдсан киноны агуулга харуулж байна. Саяхан Буриад монголыг дан буриад гэх болсон, ойрадын язгууртнуудын түүхийг зохиомлоор бий болгож чорос, өөлдийн язгууртнууд Чингис, Өгөөдэй, Хасар, Хайду нараас ангид үе удам дамжин ирсэн Дову сохорын хүү Донойн угсаа, цахарууд монголын язгууртны гол овог угсаатан<sup>1</sup> гэх мэт домог үлгэрийг тэд санаатайгаар давтсаар байна. Сүүлийн үед гэхэд л Е.И.Кычанов. Повествование об ойратском Галдане бошокту-хане. 1980, Новосибирск, Урадийн. Е.Булаг "Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзүүд". 1998. Кларендон хэвлэл. Оксфорд гэх мэт. Энэхүү санааг монголын зарим түүхчид дэмжиж байдаг нь ч харамсалтай.

Саяхан хүртэл монголчуудын үндэсний үзлийг дарах зорилтоо тайж, ноёдыг нь хоморголон устгах, овог ураг нь мэдэгдэхгүй хүмүүсийг болон баруун монголчуудын төлөөллийг төрийн тэргүүнд байлгах замаар оросууд хэрэгжүүлж чадаж байсан билээ. Хүснэгт №2

#### Төр засгийн Удирдлагад 1921 оноос:

- Харц бутач С.Данзан, шавь Д.Бодоо, харц Д.Сүхбаатар |тэд 1-3 жилд алуулсан|
- Хятадын эрлийз Б.Цэрэндорж, сросын буриад Ренчино, Жамсран, Батурин...
- Амгаланд өнчин өссөн Дамбадорж, хасаг Рысколов, дүрвэд—Бадрах, Шижээ,
- Харц Гэндэн, баяд Лааган, ойрад Жадамбаа, |тэд 2-4 жилд алуулсан|
- Боржигин тайж Р.Амар, жанжин Дэмид, |тэд 4 жилд алуулсан|
- Бутач Х.Чойбалсан-орос зөвлөх Голубчик, Чибисов, Кичиков, Скоков, Иванов...
- Дүрвэд Ю.Цэдэнбал, Ж.Самбуу,
- Баяд Ж.Батмөнх, Рагчаа, Дэжид, Молом, Дорноговийн Д.Содном...

Энэ нь нэг талаас монголчуудыг зөрчилдүүлэхэд гадныхан ашигладаг байсан боржигин ноёдтой-халх ба боржигин ноёдгүй-ойрат хэмээх зүүн барууны "ялгавар"-ыг байхгүй болгосон сайн талтай.

Гэхдээ өнөөдөр ч дотоодын эмх замбараагүй байдал үүсгэх шалтгааныг хуучин аргаар буюу ястан угсаатныг зөрчилдүүлэх замаар гадаадынхан хайхийг үгүйсгэх аргагүй. Дээрхи түүхэн байдлын үлдэгдэл буюу Төвтэйгээ зөрчилдсөн сэтгэлгээний уламжлалын үлдэгдэл зарим хязгаар нутагт байсаар байж болзошгүй нь заримдаа ажиглагддаг бөгөөд өчүүхэн зөрчлийг ч өсгөн дэвэргэх боломж их үндэстэнүүдэд үргэлжлэх байдаг. Жишээ нь: Хууль зүй дотоод хэргийн сайдыг ч иймэрхүү шалтгаанаар тагнуулын хэрэгт холбогдуулах сонирхол гадаад, дотоодод байыг үгүйсгэх аргагүйг болон түүнийг Төрийн тэргүүн Ерэнхийлөгчтэй ч иймэрхүү байдлаар зөрчилдүүлж байж болзошгүйг шинэхэн түүхийн сургамжаас дүгнэлт хийн хаана хаанаа мэдрэх ёстой.

Тухайн түүхэн явдлууд монголчуудын өөр хооронд буюу хаан ширээг залгамжлагчидын хоорондох тохиолдолууд байсан бол өнөөдөр монгол улсын нэг аймаг казах үндэстэнээс бүрдэх болсон бөгөөд тэд шашин шүтлэгийн хувьд ислам юм. Нэг талаас Зүчийн угсааныхан дундат зууны үеийн турш казахын их

<sup>1</sup> Урадийн. Е.Булаг. Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзүүд. 1998. Кларендон хэвлэл. Оксфорд.

бага жүүзүүдийг үеийн үед удирдаж ирсэн байдал, тэднийг хүнд бэрх үед Богд хаан тусламжийн гараа сунгаж газар нутаг хуваарьлаж өгсөн болон нүүдэлчин ахуй энэ хоёр үндэстэнийг ойртуулж байдаг. Негөө талаас ардчилал, хүний эрх чөлөөний сайн муу талын үр дүнд исламын шашны нөлөө казахуудын дунд улам нэмэгдэж, Монгол хэлийг сургуулиуддаа заахаа больсон, аймгийнх нь бүх шатны дарга нарын дунд ганц монгол хүн байdag болжээ. Орчин үед соел, заншлын хувьд ойртох байгаа дэлхий нийтийн хандлагын эсрэг үйл явц тэнд явагдаад байна уу гэлтэй байдал ажиглагдаж байна. Монгол хэлээ иргэд нь мэддэггүй иймэрхүү байдал арван жил үргэлжлэх юм бол улс үндэстэн юу болох вэ.

Хөгжилтэй Канад, Швейцар орнуудад хоёроос гурван хэл заавал сурах шаардлагатай байdag шүү дээ. Орон нутгийн удидлагад ажиллах төрийн албан хаагчидыг ч нэг жалга нутгийнх байлгахгүй байх төрийн бодлого ч шаардлагатай байна.

Мөн загалмайтын янз бүрийн шашны урсгал хөдөө хотгүй өргөн тархах боллоо. Ингэж ямар ноёнтойгоос биш бүр шашин шүтлэгийн болон узэл бодлын ихээхэн ялгаа монголын нийгэмд бий болжээ.

Тэрбум гаруй болон хэдэн зуун сая иргэдтэй их хөршүүдийнхээ дэргэд манай хүн амын тоо харьцуулашгүй билээ. Албан ёсны стастикаар орос, хятад иргэдийн нийт хүн амд эзлэх хувь дөрвөн хувь 12:21 байdag нь буурай орны хувьд зохистой харьцаа мөн. 19 дүгээр зууны эцсээр Монгол, Манжуурт хятад иргэдийг суурьшихыг хязгаарладаг байсан Манж гүрний төрийн бодлого, үйл ажиллагаа шинэчлэгдэн өөрчлөгдсөнөөр зургаан зуун мянган хүн амын зуун мянган эрчүүд нь лам байсан ар монголын хүрээ хийдэд олон мянган дотор иргэдлэхнэргүй залуу<sup>1</sup> шилжиж ирсэн гэдэг түүхэн баримт байdag билээ. Орос япон хоёр нөлөөний төлөө байлдаж байх ар хударгаар манжуур хятаджижсан. Монголчууд ч бэлгийн өвчинд нэрвэгдэж, ноёд тайж нарын удам тасрах болсон.

Ойрхны түүхээс 1911 оны тусгаар тогтолцоун амжилтыг үгүй болгох нэг шалтгаан нь монгол угсаатай ноёд, төвдүүд ноёрхсон лам нарын давхраажилт, хүрээ хотын хятадын худалдаачидын хооронд нууцаар явагдсан тэмцэл, эцэст нь үндэсний үзэлтнүүдийг "алан хядлах ажиллагаа"<sup>1</sup> нь цагаан сарыг "улаан сар" болгох бэлтгэл ажлын хэмжээнд хүртэл үргэлжилж байсантай холбоотой.

Энэхүү зөрчил тэмцэл 1930 оны хэлмэгдүүлэлтийн жилүүдэд коммунизмын үзэл суртлаар бамбай хийсэн Их Оросын бодлогоор, хятадын нууц бүлэглэлийн мэдээлэлд тулгуурлан монголчуудын өөрсдийнх нь гараар хийгдсэн шар, хар феодлуудыг шууд аймаглан устгах кампанит ажлаар дээд оргилдоо хүрч байсан.

1911 оны болон 1921 оны хувьсгал монголуудыг үндэстэний хувьд аварсан. Хөөгдсөн гамингуудыг дагаж нилээд хятад иргэд нутаг буцсан бол Цэдэнбал дарга ч бас үүргээ биөлүүлснээр монгол манжуур шиг болоогүй. Гэхдээ хaa ч хүчтэй байdag хятад хорооллын сэтгэхүй, түүний нөлөө хүний эрхийг тунхаглан дээдлэх болсон ардчилалын жилүүдэд улам тодорч байна.

Хэдэн жилийн өмнө "хятадын улс төрийн тагнуул монголд зорчсон нь" гэдэг номыг америкийн нэгэн номын санд уншиж билээ. Энэ нь 1920 "иод оны сүүлээр болсон бөгөөд Өмнөговиар дамжин, баригдан буцан байж арай гэж хил нэвтэрсэн тэр тагнуулч морин аялал, өртөөний гэрийн халуун хүйтэн, монгол хоолны талаар аль XII зууны Карпини, Рубрук нартай тун адилхан үнэлгээ өгч зовж зүдэрснээ бичиж үлдээжээ. Дараа нь Их хүрээнд очоод хүрээний хятад хороололд хэрхэн хүндлэгдэж хоол унд, хэл яриа, халуун ханзны хувьд хятад орчинд бүрэн орсноо дурссан байdag. Гэтэл нэг өдөр манай хилийнхэн, дотоод явдлын яамныхын айхавтар, ажилдаа үнэнчийг мэдэрч аиж бэрхшээсэн түүнийг хотын хятадууд монголын том даргын гэрт очихыг ятгахад нь бараг ухаан

<sup>1</sup> Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, Сайн ноён хан Намнансүрэн...

алдаад унаачих дөхжээ. Харин очсон хойноо нам төрийн томоохон даргын Дамбадорж бололтой\ гэр бүлийн хүн нь хятад гаралтай байснаар барагүй тэр үеийн улс төр, эдийн засгийн хэрэгт хятад угсаатай хүмүүс голлох болж байгааг зовж ичилгүй ярьж байсныг дурссан байдаг. 1990 оны эхээр зүүн өмнөд азийн хэвлэлд нэгэн дээд даргын гэр бүлийн хүн иймэрхүү байдалтай ярилцлага өгсөн тохиолдол гарсныг манай шар хэвлэлийнхэн багагүй шуугисан.

Даяаршил, хотжилтын энэ эринд улс үндэстэнүүд соёл, хэрэглээ, мэдээлийн хувьд ойртох байгаа энэ цаг үед нүүдэлчин болон суурин ахуйгаас болж ихээхэн ялгаатай байсан иймэрхүү нийгмийн зөрчилийг ухаалаг шийдэх боломж ардчилал, хүний эрхийг зөв голдирлоор нь хөгжүүлж чадсанаас л хамаарна.

Гэхдээ жижиг үндэстэний сонор сээрэмж өндөр байх нь гарцаагүй. Иргэн Гочоогийн ирээдүйн амьдралын дөрвөн төрхийг дүрсэлсэн сэтгүүл ба түүнд "Хөх толбо" дээр бичсэн Алтанбатын хариу зэрэг нь үүний сонгодог жишээ гэлтэй. Хүний эрх ба бага үндэстэний эрх ашгийн хооронд зөрчил үүсэх нь мэдээж түүнээс гарах гарцыг цаг тухайд нь зөв олох нь чухал.

#### Төгсгөл

Чингис хаан 12 дугаар зуунд аймаг түмэд, мянгатын удирдлагыг өөрийн ургаас биш хэн авьяас чадвартайг сонгон томилж байсан бол Батмөнх Даян хаан 16 дугаар зуунд феодалын бутралыг таслан зогсоох гэж зөвхөн өөрийн удмаар аймаг отгуудыг удирдуулах болсон.

Энэ хоёр арга хэлбэр түүхэн үүргээ гүйцэтгэжээ. Улс гүрэн хүчтэй байхад эхний арга болж байсан бол бутрал задралын үед өөр хоорондоо байлдах, төвөөс зугатаах шалтаг шалтгаан болж байжээ. Харин хоёр дахь нь "халх" монгол үндэстэнийг бүрдүүлэхэд гол нөхцөл болжээ дүгнэлтэд хүрч байна. Гэхдээ монголчууд Батмөнх Даян хааны буюу Толуйн удмынхан ноёрхсон нь ар, өвөр халхууд, ноёрхож амжаагүй нь Өгөөдэй, Хасарын удам ноёрхсон ойрат түмэд, хорчин аймаг, отог болон хуваагдаж ялгарах болж түүнийг нь гадаадаас дэвэргэж, түүнийг нь дотоодын зарим язгууртнууд хувийн улс төрийн зорилгodoо ашиглаж байснаас монголчууд өөр хоорондын зөрчил туйлдаа хүрч байснаас тусгаар тогнолоо алдсан.\байлдаад дийлдсэн нь үгүй\

Товчондоо Монголчууд дотоод зөрчлөө арилгасан үедээ хүчирхэг болж бас өвүүхэн зөрөө ялгаанаас үүдэлтэй дотоод зөрчлөөсөө болж унаж бутарч байжээ.

Эцэст нь даяаршил мэдээллийн гэгдэх энэ эринд манай улсын Үндэсний аюулгүй байдал үндсэндээ өөрсдөөсөө голлон хамаарч ойрын болон дунд ирээдүйд манай улсын тусгаар тогтнолд тулгарч болзошгүй хамгийн их магадлалтай аюул заналхийлэл нь гадаадын цэргийн шууд түрэмгийлэл гэхээсээ илүүтэйгээр өөрийн орны дотоод улс төр, эдийн засаг, шашин, угсаатны байдал<sup>1</sup>-аас үүдэх магадлал их юм.

Авилгал, хээл хахууль, улс төрчдийн туйлшрал, өөрсдийн бодлогогүй үйлдэл, эсхүл эдийн засгийн хямрал үүсгэх, ястан угсаатныг зөрчилдүүлэх зэргээр зарим хөршийн шууд болон шууд бус далд нөлөөлөлөөс үүдэн Монголын ардчилал сулран замхарч, төр улс нь хүчин мөхөсдэж, дотоодын эмх замбараагүй байдал \failed or failing state\ үүсч болзошгүй юм. Үүнийг далимдуулан тус улсын газар зүйн байрлалаас үүдэн цэргийн хүчээр журам дэг тогтоох нэрийн доор тодорхой улсын цэргийн хүчин орж ирэх нь хамгийн өндөр магадлалтай юм.

<sup>1</sup> Ч. Сосорбарам. монголын гадаад орчин дахь аюулгүй байдлын болзошгүй төсөөллиүүд (possible scenarios) олон улс судлал сэтгүүл.УБ., 2004

Даяаршиж, мэдээлэл холбоо хөгжиж, ардчилал хүний эрхийг дээдлэх болсон энэ цаг үед монгол үндэстэний доторхи угсаатны бага зэргийн ялгавар, үндэстэн ястаны асуудал, урд түүхэнд байгаагүй хэмжээнд хурсэн шашин шутлэг, үзэл бодлын зөрчил ялгаагаагаа нийгмийн дотоод зөрчил тэмцэл болгохгүй харин хөгжил дэвшлийн нэг хүчин зүйл болгох эсэх нь ардчилал, хуулийг дээдлэх орчин үеийн хөгжлийн түгээмэл шилдэг арга хэлбэрүүдийг, жижиг үндэстэний ухаалаг эх орон ч үзэлтэй нягт холбож чадсанаар л шийдвэрлэх боломжтой билээ.

Энэ бол ихээхэн эмзэг улс төрчид хөндөхөөс зайлсхийдэг сэдэв ч асуудлыг бугшуулах биш эртхэн мэдэрч засах арга замыг хайх нь ардчилалын нэг гол зарчим. Иймд ард түмнээ угсаа гарлаар нь хувааж бие биенээ хардуулах биш харин ирээдүйд байж болзошгүй зөрчлийн уг үндэсийг урьдчилан харж зөв дүгнэлт хийснээр хөдөгийнхэн, сахан суурьшиж эхэлсэн нүүдэлчид болон хотын хууччуулын сэтгэхүй зан үйлын зерөө ялгааг улс орны эрх ашгийн үүднээс ойртуулах арга замыг тухай бүр авч байх нь бага буурай орны төрийн чухал үүрэг. Үндэсний эв нэгдлийг хангахад иргэн бүрийн үүрэг оролцоо ч өндөр.

Иймд бид түүхээ судлахдаа аюулгүй байдлын үүднээс бодож өнгөрснөөсөө суралцан зөв дүгнэлт хийснээрээ ирээдүйгээ төсөөлж, тооцоход суралцах нь цаг үеийн чухал шаардлага болж байна.

**Abstract:** Due to its remoteness the history of Mongolia is not well known to the outside world and in many cases is wrongly interpreted. The purpose of this article is to attempt to clarify the causes which led to the breakdown of the Great Mongol Empire, which conquered most of the world in XIII-XV centuries. The rivalry among the descendants of the Chingis Khan, ended in creation of several independent kingdoms further weakening the empire without any outsiders influence. Faulty internal policies of some khans as Kubilai deteriorated the situation.

In XYI-XVII centuries due to internal conflicts among tribes-tymens, mongolia divided basicly in three parts. Thus some Mongolian leaders allied with powerful Manchu and subsequently became a dependent states od Manchu Dynasty from the 17<sup>th</sup> century up to 1911.

In 1911 Mongolia was sandwiched between its two big neighbors, Russia and China, and the principal national security goal at that time was the survival as an independent nation in the changing international environment.

Therefore this paper also describes an overview of today's ethnic issue of Mongolia and current threats and the security concerns of Mongolia, and what we need to study from history.

Mongolian scholars have suggested that Mongolia has been able to foster a homogeneous nationality, but in a time of market economy and freedom, various groups openly desire to express their ethnicity. The population includes several ethnic groups of Mongolian and even some groups of Turkic origin.

### Ном зүй:

1. Монголын нууц товчоо
2. Л.Н.Гумилев Хүн гүрэн. УБ., 2000 он
3. Далай. Монголын түүх. III боть, УБ.,
4. А.Амар Монголын товч түүх. УБ., 1989
5. Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал УБ 1978
6. Инжинаш. Хөх судрын үлгэр. УБ., 1991
7. Дамдинсүрэн Ц. Чингисийн их тахилгын өчиг, Монголын 6 түмний магтаал. 1952
8. Монгол улсын түүх, III боть. УБ., 2003
9. Ш.Лувсандорж. Монголын түүх, УБ., 2001

10. Лувсандамдин. Алтан товч. УБ., 1990
11. Д. Гонгор. Халх товчоон 1-р дэвтэр, ШУАХ, УБ. 1970
12. Нүүдлийн соёл иргэншил судлах олон улсын хүрээлэн. Төв азийн нүүдэлчдын угсаатны түүхийн асуудал. УБ., 2002
13. О.Сэржээ. Ургийн судалгаа., УБ., 1998
14. Рашид Аддин. к № д М-Л, 1952
15. Жү Яотин. Чингис хааны түүх шастир.УБ., 2002
16. Урадийн.Е.Булаг. "Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзүүд". Кларендон хэвлэл. Охфорд. 1998
17. Е.И.Нычанов. Повествование об ойратском Галдане бошокту-хане. 1980
18. Новосибирск, Б.ОНХОН.Төв аймгийн Дэлгэр хаан сумын өвгөд, дээдэс, эдүгээ үеийнхний түүхээс түүх. УБ., 2001
19. Ч.Сосорбарам. Хиадууд ба Дэлгэрхааныхан. УБ., 2003.
20. Ч.Сосорбарам. Сүүлчийн хиад. МУИС.ЭШБ.Түүх III, №228. УБ., 2004